*Засаг газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаал 2 дугаар хавсралт*

АРВАЙХЭЭР СУМЫН ӨЛЗИЙТИЙН 4 ДҮГЭЭР БАГИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН
САМДАНЦООДОЛЫН ЖАРГАЛСАЙХАН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрсэн түвшин, биелэлт | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. “Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | 1.1.“Халамжаас хөдөлмөрт бэлтгэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах | 1.1 Орлого нэмэгдсэн өрхийн тоогоор | 28 | 28 | 2024 онд 28 өрх хүнсний эрхийн бичгээс түдгэлзсэн. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| | | 1.2 Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо | 5 | 5 | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас зохион байгуулсан хөдөлмөрт бэлтгэх сургалтад 20, Амьдрах ухааны сургалтад 11 иргэн тус тус хамруулсан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 2. | 1.2.Багийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг нарийвчлан гаргаж, хөдөлмөр эрхлээгүй иргэдийг сургалтад хамруулах, ажилд зуучлах | 2.1.1 Мэргэжлийн чиг баримжаа олгох болон амьдрах ухааны сургалтад хамрагдсан иргэдийн хувиар | 80% | 100% | “Бэст Инновац” сургалтын төвтэй хамтран Худалдааны зөвлөх мэргэжлээр 3 иргэнийг сургасан. Амьдрах ухааны сургалтад ахмад настан 7, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1, өрх толгойлсон эцэг 1, зорилтот бүлгээс 2 иргэн тус тус хамруусан. | 2024.01.02 2024.12.31 | 98 |
| | | 2.2.2 Байнгын ажлын байранд зуучилсан иргэдийн тоогоор | 3 | 3 | Байнгын ажлын байранд 13 иргэнийг зуучилж, ажилд оруулсан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| | | 2.2.3 Түр ажлын байр болон улиралын чанартай ажлын байранд зуучилсан иргэний тоогоор | 20 | 20 | Нийтийг хамарсан болон түр ажлын байранд нийт 29 иргэн ажиллуулсан. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 3. | 1.3. Нэг өрх-Нэг ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 1.3.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | 80 | 100 | Тус хөтөлбөрт 14 өрхийн 79 иргэн хамрагдсан. Эдгээр өрхүүдийн судалгааг шинэчилж, гаргасан. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас зарлагдаж буй ажлын байрны зарыг хүргэн, төсөлд хамрагддаг өрхийн 4 гишүүнийг ажилд зуучилсан. Дэмжлэг | 2024.01.02 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай өрхүүдэд тусламж үзүүлж ажилласан.. | | |
| 4. | 1.4. Хувираа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын бүртгэл мэдээллийн санд баяжилт хийх | 1.4.1 Судалгаа мэдээллийн санд баяжилт хийсэн иргэний тоогоор | 10 | 10 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч 131 иргэний судалгаа мэдээллийг гаргаж, мэдээллийн санд баяжилт хийсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 5. | 1.5.Ахмад настны нийгмийн оролцоог хангах | 1.5.1 Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Ахмадын өдөрлөг, арга хэмжээг "Цахимд суралцаж, Цагаа хэмнэе уриатайгаар" багийн Ахмадын зөвлөл, Түшиг дөлгөөн ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулж тус өдөрлөгт багийн 89 ахмад настан оролцлоо. Өдөрлөгийн хүрээнд:<br>❖ Аха<br>❖ Хэн сайн дуулах вэ.<br>❖ Сайхан цайтай ээж<br>❖ Хөгжөөнт тоглоом<br>❖ Азын сугалаа<br>❖ Цахим иргэн e-Mongolia апп-ын хэрэглээ танилцуулга мэдээлэл зэрэг агуулгаар зохион байгууллаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.5.2 Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан хувиар | 80% | 80% | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 432 ахмад хамрагдахаас 215 ахмад настан хамрагдсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 80 |
| | | 1.5.3 Соёл урлаг, спорт, бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | 50% | 50% | Ахмадын "Баясах өдөр" арга хэмжээнд нийт 115 ахмад оролцсон. Хаврын баяр-2024 наадамд нийтийн бүжгийн 4 ангилалд нийт 40 хос 80 гаруй бүжигчид өрсөлдөж, 2-р байр эзэлсэн. Эрүүл мэнд эрхэм баялаг, аз жаргалын давлагаа 1 сарын аяны хүрээнд, аймгийн ахмадын хорооноос зохион байгуулсан. "Амьдрах урлаг бясалгал"-ын сургалтад нийт 30 иргэн хамруулан ажилласан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Өвөрхангай аймгийн Улаанзагалмайн хороотой хамтран олон нийтийн оролцоонд түшиглэсэн ахмадын өдрийн | 2024.01.02<br>2024.12.31 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээг зохион байгуулсан. Үүнд нийт 10 ахмадыг хамруулан ажиллаа. Ахмадын дунд жил бүр зохион байгуулдаг хийн дасгалын тэмцээнд нийт 11 ахмад хамрагдсан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлсэн "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН аяны хүрээнд Гүйлтийн тэмцээнд 1 ахмад настан оролцож дэд байр эзэлсэн. | | |
| | | 1.5.4 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан ахмадын тоогоор | 50 | 50 | Бүтэн жилийн байдлаар 55 ба түүнээс дээш насны 432 ахмад настны судалгааг шинэчлэн холбогдох мэргэжилтэнд цаг хугацаанд хүргүүлсэн. 90 болон түүнээс дээш настай 7 ахмадад Ерөнхийлөгчийн гарын бэлэг гардуулан өгсөн. Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар:<br>❖ Ахмадын цагаан сарын гарын бэлэг авах Харьяалалгүй 289 ахмад настны хүндэтгэл<br>❖ Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан 10<br>❖ Ганц бие харж хандах үр хүүхэдгүй ахмад настан 15<br>❖ Хүндэт донор 3<br>❖ Гавьяат 1 тус тус түлшний хөнгөлөлтөд холбон зуучилсан.<br>❖ Эрүүл мэндийн шалтгаанаар нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 1<br>Хөтөвч, суултуур, бөөрний даруулга, тохойн тулгууртай таяг, алхуулагч зэрэг туслах хэрэгсэлд 56, Өгөөмөр, Элма, Хужирт, Баатар ван амралт, сувилалд 107 ахмад настанг тус тус хамруулсан байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 6. | 1.6.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах | 1.6.1 Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд:<br>“Төрийн цахим үйлчилгээ, Цахим орчны аюулгүй, зөв хэрэглээ, 3 үгт хаяг буюу what3words апп, Эрсдэлгүй Өвөрхангай” аппликейшнийг танилцуулах, хэрэглэх талаарх сургалтыг зохион байгуулж, | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зорилтот бүлгийн буюу хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэнийг хамруулсан. | | |
| | | 1.6.2 Соёл урлаг, спорт, бусад арга хэмжээнд хамруулсан хувиар | ~~50~~ 8 | ~~30~~ 20 | Биеийн тамир спортын газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэнээс бие бялдарын сорилыг авч ажиллалаа. “Бүтээлч гар НҮТББ” байгууллагатай хамтран багийнхаа 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сонгуулийн боловсрол олгох сургалтад хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагчдын үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг таниулах сурталчлах, холбон зуучлах зорилгоор хувиараа бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж 10 иргэнийг сургалтад хамрууллаа. Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулсан Ерөөлч, магтаалчдын аймгийн анхдугаар уралдаан гоцлол дууны төрөл 1 иргэнд оролцуулж “Дэд” байр эзэлсэн. Арабын нэгдсэн Эмират улсад зохион байгуулагдсан Жюү жицүгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний пара төрөлд 1 иргэн оролцож, Дэлхийн аваргын хүрэл медаль авсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.6.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулсан иргэдийн хувь | 100 | 80 | Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар:<br>❖ Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхэд 16<br>❖ Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай иргэн 11 нийт 27 иргэдийн материалыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт 1 удаагийн тэтгэмжид 1, байнгын ажлын байранд- 2, улирлын чанартай ажилд тус тус холбон зуучилж ажиллаа. Олон улсын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зорилтот эмэгтэйчүүдэд | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэсэн "Ерэн есөн сарнай" нөлөөллийн арга хэмжээнд багийнхаа хөгжлийн бэрхшээлтэй 9 залуу эмэгтэйг уг арга хэмжээнд оролцууллаа. | | |
| | | 1.6.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувиар | 80 | - | Хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхдийн судалгааг шинэчлэн гарган сангийн мэдээлэл баяжилт хийсэн. Хамрагдалтын байдалаар:<br>❖ СӨБ 2<br>❖ ЕБС 5<br>❖ ГЭР 8 | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 7. | 1.7.Багийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, үр дүнд хүрэх | 1.7.1. Хамтарсан багийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 95 | 100 | Хамтарсан багийн 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 5 зорилт, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тайлант хугацаанд хамтарсан баг 3 удаа хуралдаж, 4 кейс дээр нь хяналт тавин ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.7.2 Үр дүнтэй хаасан кейсийн тоогоор | 7 | - | Хаасан 3 кейс | 2024.01.02<br>2024.12.31 | |
| | | 1.7.3 Хүүхдийн эрсдэлийн мэдээллийн санд баяжилт хийсэн тоогоор | - | - | Архины хамраалтай, үл хайхрах, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай 18 өрхийн 54 хүүхдүүдийн судалгаа шинэчлэн баяжилт хийсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 8. | 1.8. Гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 1.8.1 Залуу гэр бүлийн хөгжил, төлөвшилд чиглэсэн сургалт, арга хэмжээний тоогоор | 3 | 2 | -13 багийн нийгмийн ажилтан хамтран зохион байгуулсан "Жаргалтай гэр бүл-Жаргалтай амьдрал" өдөрлөгт 2 гэр бүлийг оролцуулсан.<br>Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан гэр бүлийн бат бөх харилцааг бий болгох, хариуцлагатай гэр бүлийг бэхжүүлэх, үлгэр дуурайлал болсон 1 гэр бүлийг уг арга хэмжээнд оролцууллаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.8.2 Тэмдэглэлт баярыг угтан зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоогоор | 1 | 1 | Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хүүхэд байх хөөрхөн" уриатай нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж зорилтот | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүлгийн 75 хүүхэд, 32 эцэг, эхийг оролцуулсан. | | |
| 9. | 1.9. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | 1.9.1 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар | 80 | 100 | Цагдаагийн газраас ирсэн мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3 иргэн, багийн нутаг дэвсгэрт хэрэг, зөрчил үйлдсэн 1 мэдээллийн дагуу холбогдох өрхүүдээр явж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, хууль, архи, тамхины хор уршгийн талаар нэмэлтээр мэдээлэл өгч ажилласан.<br>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн талаарх мэдээллийг багийн хаалттай болон нээлттэй группээр дамжуулж, давхардсан тоогоор 800 гаруй иргэнд хүргэж ажиллалаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.9.2 Гэр бүлийн хүчирхийллийн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувиар | 90 | 100 | Гэр бүлийн маргаан, хүчирхийлэлтэй холбоотой мөрдөгчийн 4 мэдэгдэл ирсний мөрөөр хүчирхийлэл үйлдсэн иргэнтэй уулзаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Дахин энэ гэр 2 бүл дээр хэрүүл маргаан гараагүй гомдол шийдвэрийн дагуу хариуг тухай бүр нь өгч ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 1.9.3 Хохирогчид үзүүлэх үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээнд хамруулсан иргэний тоогоор | 20 | 25 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэж болзошгүй иргэдэд сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгууллаа. Нийт 25 иргэнийг хамрууллаа.<br>-Хүний эрхийг хамгаалах механизмыг таниулах сургалтад 10 иргэнийг хамруулан ажиллаа.<br>-Иргэдэд хууль сурталчлах зөвлөгөө мэдээлэл өгөх “Явуулын үйлчилгээг” зохион байгуулж, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор уг арга хэмжээг зохион байгуулснаар Арвайхээр сумын 356 иргэнд хууль эрх зүйн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгч үүнээс | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4-р багийн 33 иргэн хамрагдаж 7 айл өрхөөр орж зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа. | | |
| **ХОЁР. “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | 2.1 Иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтыг боломжит хэлбэрээр зохион байгуулах | 2.1.1 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн хувиар | 25 | 30 (60) | Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамрагдвал зохих 3209 иргэдээс хамрагдсан 2838 иргэн байна. Үүнд:<br>-Артерийн гипертензи 1511 иргэн хамрагдалтын хувь 92,5 хувьтай<br>-Чихрийн шижин хамрагдсан иргэн 655 хамрагдалтын хувь 70,1 хувьтай<br>-Хөхний хавдар хамрагдсан иргэн 435 хамрагдалтын хувь 100 хувьтай<br>-Умайн хүзүү хамрагдсан иргэн 237 хамрагдалтын хувь 66 хувьтай | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 2.1.2 Эрүүл мэндийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 1 | 1 (2) | Багийн жирэмсэн ээжүүдэд эрүүл зөв зохистой хооллолтын талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэж эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. 8 удаагийн сургалтанд нийт 131 жирэмсэн ээжүүд хамрагдсан. Мөн 6 төрлийн 576 ширхэг гарын авлагыг олшируулан иргэдэд хүргэсэн. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийт 16 төрлийн жирэмсэн үеийн тулгардаг бэрхшээлүүдийн талаарх мэдээллийг байршуулахад 3264 иргэний хандалтыг авсан байна. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 2.1.3 Хорт зуршил, мансууруулах бодис, сэтгэцийн өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоогоор | 2 | 2 | -Дэлхийн тамхины эсрэг өдрийг тохиолдуулан тамхины хор хөнөөллийн талаар иргэдэд суртчилан багийнхаа хаалттай групп болон нээлттэй группаар дамжуулан мэдээлэл сурталчилгаа оруулж ажиллалаа.<br>-Жендэрийн үндсэн ойлголт, бэлгийн замын халдварт өвчин түүнээс урьдчилан сэргийлэх, архи тамхины хэрэглээ түүний хор уршгийн талаар сургалт мэдээлэл 4 төрлийн гарын авлага өгсөн. Үүнд нийт давхардсан тоогоор 97 иргэн хамрагдсан | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.<br>-Иргэн аж ахуй нэгж байгууллагад архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ түүний хор хөнөөлийн талаар ойлгуулах, цаашид үүсэж болох өвчлөлөөс сэргийлэх “Одоо л больё” нэгдсэн арга хэмжээнд 20 иргэнийг хамруулсан.<br>11 сарын 20-нд Электрон тамхины хор уршиг сэдвээр Түшиг дэлгээн ӨЭМТ-ийн НЭМА н.Цэвэлмаа сургалт хийж 10 дугаар ангийн 28 сурагч хамрагдсан. | | |
| 2. | 2.3.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, нийтийн биеийн тамираар хичээллэгчдийг нэмэгдүүлэх | 2.2.1 Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийг нэмэгдүүлсэн хувиар | 10% | 10% | Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах зорилгоор багийнхаа 90 иргэнээс уг сорилыг авч ажиллаа. Сорилыг авснаар илүүдэл жин, жингийн дутагдалтай иргэдийг биеийн тамираар хичээллүүлэх тогтмол дасгал хөдөлгөөн хийлгэх зорилгоор үе шаттай зохион байгуулсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 3. | 2.4. Соёлын биет бус өв тээгчдийн судалгаанд баяжилт хийх шавь сургалтыг хөгжүүлж, өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлнэ. | 2.3.1.Судалгаанд баяжилт хийсэн тоогоор | 5 | 5 | Соёлын биет бус өв тээгчдын нийт 7 иргэдийн судалгааг гаргаж ажиллаа. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 2.3.2 Соёлыг биет бус өв тээгчийг сурталчилсан арга хэмжээний тоогоор | 1 | 1 | -2024 онд Соёлын яамнаас Сүхбаатарын талбайд 21 аймгийн “Монгол гэр” үзэсгэлэнд оролцож багийн иргэн Г.Амирдаабазар нь 8-н ханатай сийлбэртэй гэрээрээ оролцож, Монгол улсын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан.<br>-“Бүх нийтийн соёл урлагийн боловсролын өдрүүд” арга хэмжээний соёлын өвийн өдөрт оролцсон | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 4. | 2.4. Өрхийн дунд угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх, сургалт арга хэмжээг оновчтой хэлбэрээр зохион байгуулах | 2.4.1 Угийн бичиг хөтлөлтийн судалгааний санд баяжилт хийх угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх хувиар | 7 | 10 | 2023 онд 98 иргэн байснаас ургын бичиг хөтөлдөг 107 өрхийн судалгаа гаргаж мэдээллийн санд баяжилт хийсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 2.4.2 Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | 1 | 2 | Арвайхээр сумын 13-н багийн нийгмийн ажилтан, Энх итгэлийн гэгээ төрийн бус байгууллагатай хамтран “Нэг өрх Нэг угийн бичиг” аяны хүрээнд сургалт зохион | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. “Жаргалтай гэр бүл-Жаргалтай амьдрал” өдөрлөгт “Ургийн бичиг” хэрхэн хөтлөх талаар сургалтад 4 иргэнийг хамрууллаа. | | |
| 5. | 2.5. Зорилтот жилийн ажлыг сурталчилах, зохион байгуулах | 5.1 Зохион байгуулсан сургалт арга хэмжээний тоогоор | 2 | 2 | Цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилтот жилийн хүрээнд:<br>“Төрийн цахим үйлчилгээ, Цахим орчны аюулгүй, зөв хэрэглээ, 3 үгт хаяг буюу what3words апп, Эрсдэлгүй Өвөрхангай” аппликейшнийг танилцуулах, хэрэглэх талаарх сургалтыг зохион байгууллаа. Үүнд: ϖ Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийн талаар ХХҮГ-ын мэргэжилтэн Г.Оюунаа<br>ϖ Багийн нутаг дэвсгэрт болон аймаг, сумын хэмжээнд ихэвчлэн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаар болон гэмт хэрэг, зөрчил 2-ын ялгаа, Хүүхэд хамгааллын тухай хуулиар Багийн цагдаа А.Эрдэнэцогт<br>ϖ Хог хаягдлын тухай хуулийн холбогдох заалт, хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах нь” сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Л.Ганзориг нар мэдээлэл өгч, иргэдийн асуусан асуултад хариулт 39 иргэн хамрагдсан.<br>“Цахимд суралцаж, Цагаа хэмнэе уриатайгаар” багийн Ахмадын зөвлөл, Түшиг дөлгөөн ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулав. Өдөрлөгт багийн 89 ахмад настан оролцлоо. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 6. | 2.6. Сум, багийн хэмжээнд туршлага болохуйц шинэ ажил санаачлан хэрэгжүүлэх | 2.6.1.Шинээр санаачилсан ажлын тоогоор | - | - | Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон улсын өдрийг тохиолдуулан “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”-ийн талаар иргэдэд мэдээлэл хүргэж сурталчлан таниулах нөлөөллийн ажлыг зохион байгууллаа.<br>“НАЙЗ БАЙЯ” нөлөөлөлийн арга хэмжээ зохион байгууллаа. Уг арга хэмжээнд | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ТҮШИН ДӨЛГӨӨН ӨЭМТөвийн нийгмийн ажилтан н.Цэвэлмаа Электрон тамхины хор уршиг, Багийн нутаг дэвсгэрт болон аймаг, сумын хэмжээнд ихэвчлэн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн талаар болон гэмт хэрэг, зөрчил 2-ын ялгаа, Хүүхэд хамгааллын тухай хуулиар, Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй, Эерэг хандлага сэдвээр сэтгэлзүйч Т.Юмжирдулам нарын урин нөлөөлөлийн арга хэмжээг ЕБ-ийн 2-р сургуулийн 10б ангийн хүүхдүүдийн дунд зохион байгуулан нийт 27 хүүхэд оролцож, Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй " "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхдийн эрх гэх мэт гарын авлага өгч ажиллаа. | | |
| Гурав. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | 3.1. Жилийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, батлуулах | 3.1 Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймаг, сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж төлөвлөгөөг бүтэн жилээр гарган төсвийн шууд захирагчид хянуулж дүгнүүлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 2. | 3.2 Хугацаатай албан бичиг, тайлан мэдээ, судалгааг бүрэн үнэн зөв гаргаж хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэх | 3.2.1 Өргөдлийн шийдвэрлэлтийн хувиар | 100 | 100 | Хорихоос суллагдсан 2 иргэний материалыг 1 удаагийн тэтгэмжид хамруулан ажиллалаа. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоолгохоор хүсэлт гаргасан 3 иргэний өргөдлийн материалыг бүрдүүлэн өгч, шийдвэрлүүлэн ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| | | 3.2.2 Хугацаатай албан бичиг болон мэдээ хүргүүлсэн хувиар | 100 | 100 | Хугацаатай 42 албан бичиг ирснийг дагуу цаг алдалгүй үнэн бодиттой файлаар болон цаасаар холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлж ажилласан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

82

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.3 Сарын ажлын мэдээний тоогоор | 12 | 12 | Сар бүр хийж хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудсыг зохион байгуулагчид гарган өгч ажиллаж байна. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 3. | 3.3. Статистик мэдээ тайлан, тооллого судалгаа, мэдээллийн санд баяжилт хийх | 3.1 “Нийгмийн зарим үзүүлэлт” гаргасан судалгааны тоогоор | 8 | - | Бүтэн жилийн байдлаар шинэчлэн гаргасан.<br>Хэрэгжих хугацаа болоогүй. | 2024.01.02 2024.12.31 | - |
| 4. | 3.4. Ес зүйн болон ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах | 3.4.1 Иргэдээс гомдол мэдээлэл ирүүлээгүй байх | - | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | Ёс зүйн болон ашиг сонирхолын зөрчил гаргаагүй. | 2024.01.02 2024.12.31 | 100 |
| 5. | 3.5 Байгууллагаас зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилгатай оролцох | 3.4.2 Зохион байгуулсан ажилд оролцсон хувиар | - | Арга хэмжээний тоо | Байгууллагын спорт хамтлагаас зохион байгуулсан байгууллагын аварга шалгаруулах волейболын тэмцээнд оролцсон. Төрийн байгууллагуудын аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд байгууллагаа төлөөлж оролцсон. | 2024.01.02 2024.12.31 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан | Хамруулсан иргэдийн тоогоор | - | 80-с доошгүй | Өвөл, хаврын улирлын нийтийн их цэвэрлэгээг 4 удаа зохион байгуулж, цэвэрлэгээнд давхардсан тоогоор нийт 150 иргэн оролцож, 20 тонн хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлж ажилласан. Мөн хог ачилт, тээвэрлэлтийн хуваарьт хяналт тавьж, иргэдээс ирсэн гомдол, саналыг тухай бүрд шийдвэрлэж ажиллаж байна. | I-IV улирал | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээ**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхлэх, дуусах хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Арга хэмжээ 1** Сэтгэл зүйчийн чадавхижуулах сертификаттай сургалтанд хамрагдах | Сургалтанд хамрагдсан тоогоор | Анхан шат | - | Отгонтэнгэр Их сургуулийн Сэтгэлзүйчийн ангид бүртгүүлсэн. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Нийгмийн ажилтнуудын богино хугацааны чадавхижуулах сургалтанд хамрагдах | Сургалтанд хамрагдсан тоогоор | - | - | Т.Юмжирдулам сэтгэлзүйчийн сургалтад хамрагдсан. | 2024.01.02<br>2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ӨЛЗИЙТ 4 ДҮГЭЭР БАГИЙН
НИЙГМИЙН АЖИЛТАН ............................. /С.ЖАРГАЛСАЙХАН / 2024.11.24